

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 18

Мандалговь хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв, сая. төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
<b>Мал аж ахуйн салбар</b>							
1	Бэлчээрийн менежментийг сайжруулж, малын тоог бэлчээрийн даацад тохируулах	Малчид хувь хөрөнгө-20,0 сая	Эдийн засгийн эргэлтэд оруулсан болон хүнсэнд хэрэгцээлсэн мал тоогоор	967,1	980,1	Таваарын буюу хэрэгцээний нийт 1029908 малаас 813734 буюу малын 79,1 хувийг эдийн засгийн эргэлтэд, 216122 мал буюу 20,9 хувийг хүнсэнд хэрэгцээлсэн. Нийслэлийн иргэдийг махаар хангах зорилгоор 2024 оны 12 сарын 12-ноос 12 сарын 21 хүртэлх хугацаанд “Хоршооноос-хотынхондоо” уриан доор “Өвлийн идэш-2024” арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Баянжаргалан, Сайнцагаан, Дэлгэрхангай, Сайхановоо сумдын малчид, мал	100

						бүхий иргэд, хоршоологчид оролцсон. Сумдаас нийт 9 хоршооны 38 малчин, хоршоологч оролцож нийт 204 тн мах, 20,5 тн дайвар бүтээгдэхүүн борлуулж нийт 2,4 тэрбум төгрөгийн орлого олсон байна.
		УТ-94,9 сая.төг ОНТ-660,0 сая.төг, Малчид-173,0 сая.төг	Бэлчээр усжуулалтын хувь	50,9	51,5	2024 онд инженерийн хийцтэй 18 худаг, 23 цооног шинээр гарган, энгийн уурхайн 29 худгийг сэргээн засварлаж 61500 га бэлчээрийн талбайг усжуулж бэлчээр усжуулалтыг өмнөх оноос 0,9%-иар нэмэгдүүлж, аймгийн хэмжээний нийт бэлчээрийн талбайн 51,8% усжуулсан.

		<p>УТ-239,2 сая ОН-14,0 сая</p>	<p>Үлийн цагаан оготной тэмцсэн талбай мян/га</p>	40.0	40.5	<p>Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн 253,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэрэн нийт 8 сумын 60,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн болон энгийн механик аргаар үлийн цагаан оготной тэмцэж, нөхөн сэргээх ажлыг хийсэн. Мөн дээрх сумдад шувууны үүр 100 ширхэг, утагч багаж 8 ширхэг, үлий цөмлөгч 8 ширхгийг хуваарилан олгосон.</p> <p>Тэмцсэн хээрийн техникийн үр дүн 82.7 хувьтай. Өмнөх оноос 20,0 мян.га талбайгаар нэмэгдүүлэн тэмцсэн.</p>	
		ОН-	<p>Орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бэлчээр мян/га</p>	-	5200	<p>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Эрдэнэдалай сумын Дэлгэрэх уул орчмын</p>	

						6000 га бэлчээрийн талбайг сум дундын тусгай хэрэгцээний отрын бүс нутаг болгон авч цаг хүндэрсэн үед ашиглаж байна.	
2	Малын тоо толгойн албан татварын орлогын 50-аас багагүй хувийг үхэр сүргийг бүртгэлжүүлэхэд зарцуулах	Хувь хөрөнгө - 500,0 мян,төг	Ээмэгжүүлсэн үхрийн тоо	119	220	2023-2024 оны хаваржилт хүндэрч мал олноор хорогдсон тул сумдууд малын тоо, толгойн албан татварыг чөлөөлсөн. Өндөршил, Баянжаргалан, Дэрэн сумд энэ онд 102 үхэр нийт 221 үхэр ээмэгжүүлж ялган тэмдэгжүүлсэн.	100
			Бүртгэлжүүлсэн үхрийн тоо	119	220	Энэ онд ялган тэмдэгжүүлсэн 102 үхрийг малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.	
3	Бог малын хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Хувь хөрөнгө- 5,0 сая	Ялгавал зохих хээлтүүлэгч хувиар	50.2	55	Хээлтүүлэгч малыг хээлтүүлгийн бус үед нь эх сүргээс нь ялган суурилсан.Нийт ялгавал зохих 22013 хээлтүүлэгчээс хуц 6992 буюу 57,7 хувь, ухна 5242 буюу 52,9 бүгд 12234 буюу 55,5 хувийг нь ялган суурилсан.	100
4	Сумдын хөдөө аж ахуйн тасагт дутагдалтай байгаа малзүйч мэргэжилтний ажлын байранд мэргэжлийн боловсон хүчинг бодлогоор дэмжиж ажиллуулах	ОНТ-	Дэмжлэг үзүүлсэн албан хаагчийн тоо	0	3	Дундговь аймаг дахь Политехникийн коллежийн "Мал зүйч"-ийн ангид 5 сумаас нийт 9 иргэн суралцаж анхны төгсөлтөө хийх гэж байна. Цаашлаад оюутнууд ХААИСургуулийн Зоо инженер технологийн	

					<p>ангид 1,5 жилээр суралцаж дээд мэргэжлийг эзэмшиж төгсөнө. ХААИС-ийн МААБТСургуулийн бакалаврын зэрэгтэй дэвшин суралцах гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Өлзийт, Гурвансайхан, Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасагт ажиллахаар 3 албан хаагч 2023 оноос эхлэн ХААИС-ийн “Зоо инженер технологи”ийн” 2,5 жилийн эчнээ ангид суралцаж 1-р курсээ төгссөн. Мөн 2024 онд ХААИС-ийн Зоо инженер технологийн ангийг төгссөн 1 оюутан сургалтын төлбөрийн 4,5 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдан одоо тус газарт ажиллаж байна. Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр болон сумын ЗДТГ-аас тус оюутнуудтай гэрээ байгуулж, оюутнуудын суралцах хугацааны сургалтын төлбөрт нийт 11,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан. Нийт 4 албан хаагчид 16,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.</p>	100
--	--	--	--	--	--	-----

5	Өвөлжөө, хаваржааны бууцны хөлд ногоон тэжээл тариалж тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх	Төсөл хөтөлбөр 79.0 сая	Тэжээлийн ургамал тариалсан өрхийн тоо	16	17	Аймгийн Засаг даргын 2024 оны А/330 дугаар захирамжийн дагуу малчдыг тэжээлийн ургамал тариалуулахаар 15 суманд 50,5 тн овьёос, 17,5 тн улаан буудайн үрийг хуваарилан олгосны дагуу Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 75 малчин өрх 49,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалсан.	100
			Хураан авсан ургацын хэмжээ /тн/	15	16	13 сумын 75 малчин өрх 49,7 га талбайд тэжээлийн ургамал тариалж 57,2 тн ургац хураан авч өмнөх оноос 42 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
<b>Газар тариалангийн салбар:</b>							
6	Сумдад агро-ойн аж ахуй байгуулах, жимс, жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэхэд газар, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	УТ-210,0 УТ-429,0 Хувийн хэвшил-0,8	Жимс, жимсгэнийн тариалалтыг 10 хувиар нэмэгдүүлэх	77,8 га	85,58 га	Тус онд аймгийн хэмжээнд нийт 85,58 га талбайд жимс жимсгэнийн тариалалт хийж, өмнөх оноос 7,7 га буюу 10 хувиар нэмэгдүүлэн ажилласан. 1. Сайнцагаан сумын “Арвин их сан” ХХК нь жимс, жимсгэнэ тариалалтын зориулалтаар ЖДҮХСангийн хөнгөлөлтэй зээлд хамрагдаж 210.0 сая төгрөг авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.	66,6

						Энэ онд 3 га талбайг хашаажуулж, шинээр 3 га талбайд алимны төгөл байгуулах зорилгоор 4 төрлийн сортын алимны суулгац тариалсан. Ургалтын 90 хувьтай ургасан байна. Адаацаг, Луус, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумд 4,7 га талбайд /чацаргана, алим, үхрийн нүд/ тариалсан. 4,6 тн-ийг хураан авч, орон нутгийн зах зээлд борлуулсан байна.	
			Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн плантацийн ашиглалтын хувь	-	100	Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн плантацийн ашиглалт 100 хувьтай байна.	
			Жимс, жимсгэнийн суулгацын ургалтын хувь	-	80	Жимс, жимсгэнийн суулгацын ургалтын 50 хувьтай байна.	
7	Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, газар олгох, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.	Хувийн хэвшил – 250.0 УТ-179.5	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	0	1	1.Сайнцагаан сумын Мөнгөлөг МД ХХК өвлийн хүлэмжний зориулалтаар Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 179.5 сая төгрөгний хөнгөлөлтэй зээлд хамдагдсан. Улмаар 0,5 га талбайг хашаажуулж, шинээр 10*30=300м.кв хүлэмжинд хүнсний нарийн ногоо	

						<p>тариалж, нийт 3,2 тн өргөст хэмх хураан авсан байна.</p> <p>2. Сайнцагаан сумын иргэн С.Амарбаясгалан Бүгд найрамдах солонгос улсын технологиор барьсан 3 улирлын 280*4=1120м.кв хүлэмжинд эрт ургацын байцаа, өргөст хэмхийг тариалж, 16,5 тн-ийг ургац хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлсэн. Дээрх 3 улиралын хүлэмжийг хувийн хөрөнгө оруулалтаар буюу 250,0 сая төгрөгөөр барьж байгуулсан байна.</p>	100
			Өвлийн хүлэмжид тариалсан талбай хэмжээ м.кв	1780	2080	Аймгийн хэмжээнд өвлийн хүлэмжид 2980 м.кв тариалалт хийж, өмнөх оноос 1200 м.кв талбай нэмэгдсэн үзүүлэлтэй байна.	
			Хураан авах ургацын хэмжээ тн	19,02	23	Нийт 8 нэр, төрлийн хүнсний ногоо тариалж 37.08 тн ургац хураан авсан байна. Өмнөх оноос 18 тн -оор өссөн үзүүлэлттэй байна.	
8	Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах	Хувийн хэвшил – 22,0	Шинээр нэмэгдүүлсэн талбайн хэмжээ (га)	57	57,5	Тариалангийн талбайг хамгаалах зорилгоор Сайнцагаан, Эрдэнэдалай,	



						Гурвансайхан, Адаацаг сумд ойн зурвас байгуулж 1500 ширхэг /Улиас, хайлаас, агч, сухай / модыг тариалсан байна. Аймгийн хэмжээнд тариалангийн талбайг хамгаалж нийт 57,8 га-д ойн зурвас бүхий мод бут тариалж, өмнөх оноос 0,8 га талбайгаар нэмэгдсэн.	100
9	Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.3.2 дахь заалт “Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллах	ОНТ – 13,5	Мэдээлэл, сурталчилгаа хүргэсэн иргэний тоо	50	80	“Дундговьо ногооруулъя” дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан Төмс, хүнсний ногоо, хүлэмж, жимс, жимсгэнэ тарьж ургуулах иргэдэд зориулсан сургалтад хамрагдсан 15 сумын 71 ногоочин, Япон улсын Жайка ОУБ-тай хамтран үдийн хоолны талаарх мэдээлэл сургалтад хамрагдсан 28 ногоочин, Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоо"-той хамтран зохион байгуулсан 15 ногоочин, сумдын Хөдөө аж ахуйн тасгийн 15 мэргэжилтнүүдэд тус тус мэдээллийг хүргэсэн. Нийт 4 удаа 129 иргэнд сурталчилгаа, танилцуулга мэдээллийг хийсэн. 10 иргэн хамрагдах хүсэлтэй байсан хэдий ч тоног төхөөрөмжийн шалгуур үнэ өндөр байсан тул хамрагдаж чадаагүй	100

						болно.	
<b>Хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр</b>							
10	Ноосон түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, хонь хяргах төхөөрөмжийг нэвтрүүлж түүхий эдийн чанар, гарцыг дээшлүүлэх	Хувийн хэвшил - 5,0	Хонь хяргах төхөөрөмжийн сургалтад хамрагдсан хүний тоо	15	18	Сайнцагаан сумын “Ээлтэй дулаахан номгон” хоршооны гишүүн 9 малчин, бусад сумдын суралцах сонирхолтой 10 мал бүхий иргэн нийт 19 иргэнд цахилгаан хайчаар хонь хяргах сургалтыг 5 өдөр зохион байгуулсан.	100
			Хонь хяргах төхөөрөмжөөр бэлтгэсэн ноосны хэмжээ (кг)	180	300	Сургалтын хугацаанд 250 хонь хяргаж 310 кг ноос бэлтгэсэн. Хяргах төхөөрөмжөөр хяргахад 1 хониноос авах ноосны хэмжээ 0,1-0,3 граммаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
		Хувийн хэвшил - 456,0	Анхан шатны тордолт хийсэн ноосны хэмжээ (тн)	10	15	“Их онь” ХХК-ний Ноос угаах үйлдвэр нь анхан шатны тордолт, ангилалтыг хийж 152 тн ноосыг угааж, зах зээлд борлуулсан.	
11	Арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, малыг эрүүлжүүлэх, нядалгааны үеийн гэмтлийг бууруулах	Хувийн хэвшил -	MNS 0060:2013 стандартыг мөрдүүлэх зохион байгуулсан сургалтын тоо	-	1	Судалгаа хөгжлийн хүрээлэнгээс Арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, малыг эрүүлжүүлэх, нядалгааны үеийн гэмтлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан цахим сургалтад 15 сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн болон Сайнцагаан сумын 3 мал	100

						төхөөрөх цехийн 8 ажилтныг хамруулсан. 3 мал төхөөрөх цехэд MNS 0060:2013 стандартыг мөрдүүлж эхэлсэн.	
			Арьс шир хуулах төхөөрөмж ашиглан бэлтгэсэн арьс, ширний тоо	61308	61350	Бог малын арьс хуулах төхөөрөмжийг ЭЭТМО ХХК-ийн мал төхөөрөх цехэд байршуулан 45 малын арьсыг гэмтээхгүйгээр хуулж зах, зээлд нийлүүлсэн. Ингэснээр төхөөрөмж ашиглан хуулсан арьсны тоо 61353 болсон.	
12	“Шинэ хөдөө” төслийн хүрээнд аймаг орон нутагт хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	УТ-79,9 ОНТ-647,0	Тоног төхөөрөмж шаардлагатай цехд шилжүүлсэн эсэх (Тийм 1, Үгүй 0)	0	1	Эрдэнэдалай сум нь арьс, шир, ноос боловсруулах зориулалт бүхий 32*6 харьцаатай 4 өрөө ажлын байрыг ОНТөсөвт санхүүжилтийг суулган барьж байна. Барилгын явц 40 хувьтай. Энэ ажлын байр баригдсанаар “Шинэ хөдөө” төслөөр ирсэн тоног төхөөрөмжийг байршуулна. Тус төхөөрөмжийг ашиглах гэрээг иргэн У.Энхбаяртай байгуулан ажиллаж байна.	50
			Арьс, шир боловсруулах тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх зохион байгуулсан сургалтын тоо	0	1	Судалгаа хөгжлийн төв, аймгийн ХХААГ-тай хамтран 2024 оны 11 сарын 08 өдөр Эрдэнэдалай сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн болон тус төхөөрөмжийг ашиглахаар гэрээ байгуулсан У.Энхбаяр нарыг	

						арьс, шир боловсруулах тоног төхөөрөмжийн сургалтад хамруулсан.	
13	Дахин боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд сургалтыг Мэргэжлийн холбоог түшиглэн зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх.	ОНТ-	Зохион байгуулсан сургалтын тоо	2	2	БОГ-тай хамтран сумдын байгаль орчны 12 мэргэжилтэн, ЕБС-ийн 79 сурагч, цэцэрлэгийн 82 хүүхдэд, Эх дэлхийн цаг арга хэмжээгээр 45 хүүхдэд, Дэлгэрцогт сумын 30 иргэн, 35 сурагчид, Ахмадын хорооны 80 ахмад, Эрдэнэдалай суманд 52 сурагч, солонгос хэл сургалтын 30 оюутан залуучуудад хог хаягдал, хог хаягдлаа ангилан ялгах тухай сургалт зохион байгуулсан. Экосум ТТБ-тай хамтран 15 сумын 100 иргэнд “Монгол улсаа хоггүй орон болгоё” хог хаягдлын сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулсан. Дэлгэрцогт суманд хог хаягдлыг ангилан ялгах, мэргэжлийн байгууллагад дахивар тушаахад анхаарах асуудал сэдвээр сургалт зохион байгуулж 30 хүнийг хамруулсан. Баянжаргалан Сумын 40 гаруй иргэн, сургуулийн 120 гаруй сурагчдад, уул уурхайн 12 ААН-д хог	100

						<p>хаягдлын талаар сургалт сурталчилгаа зөвлөмж зэргийг хүргэн ажилласан. Говь-Угтаал Иргэн айл өрх ААН-үүдэд хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах , нүхэн жорлонгийн талаарх гарын авлага тарааж мэдээлэл хүргэж дадал суулгах чиглэлээр 4 ААН, 25 өрх, давхацсан тоогоор 78 иргэнд тараах материалыг хүргэн ажиллаад байна. Танхимын сургалт хийгдээгүй болно. Эрдэнэдалай Багийн иргэдийн нийтийн хурал болон АСА Цогцолбороор хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах, хуулийн хэрэгжилт, цаг үеийн байдал, хогийн нэгдсэн цэгийн ашиглалт зэрэг сэдвээр мэдээлэл сургалтыг хийж давхардсан тоогоор 265 иргэн хамрагдсан байна. Нийт 5 удаагийн сургалт, мэдээлэл өгсөн арга хэмжээ болж, 1000 иргэнийг хамруулсан.</p>	
			Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	125	150	Сургалт, мэдээлэлд хамрагдсан нийт хүний тоо 1000.	
14	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний	ОНТ-800,0 сая.төг	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувь	70.4	79	Сургууль, цэцэрлэгийн хэрэгцээнд нийлүүлж буй төрийн худалдан авалтад	100

	нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах		Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хэмжээ /сая.төг/	668,3	750,0	дотоодын үйлдвэрлэл 79 хувийг эзэлж байна. Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн нийлүүлэлт 15,400 кг бүтээгдэхүүн буюу 800,0 сая.төгрөг байна.	
<b>Хүнсний үйлдвэрийн салбарын чиглэлээр</b>							
15	УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний боловсруулах үйлдвэрт олгосон зээлийн хэрэгжилтийг хангах, зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих	УТ-346,5 сая	Зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд тавьсан хяналтын тоо	0	1	2023 онд Хүнсний боловсруулах үйлдвэрт эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан тус аймгийн Сайнцагаан сумын Мандалговь Хүнс ХХК-ын үйл ажиллагаанд 2024 оны 5-р сарын 24-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй газрын даргын баталсан “Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд хяналт тавих удирдамж”-ийн дагуу дээрх ААНэгж дээр ажиллалаа.  Мандалговь Хүнс ХХК нь 2023 оны 5 сарын 31-нд Хаан банкнаас хөрөнгө оруулалтын 242,3 сая.төгрөгийн, Эргэлтийн хөрөнгийн 104,1 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт тус тус хамрагдсан. Тус үйлдвэр нь хөрөнгө оруулалтын зээлийг авснаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг 2 дахин	100

						<p>нэмэгдүүлж дараах тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан талаарх баримтуудтай танилцлаа. Худалдан авсан тоног төхөөрөмжүүдийг хүснэгтээр харууллаа. Нийт 154,1 сая.төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтын зээлээр авч компанийн үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. /баримтыг зургаар орууллаа/ Жич: дээр дурдсанаас гадна үйлдвэрийн цех тасалгаануудын агааржуулагчийн системийг шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	
			Бүтээгдэхүүний хэмжээ тн	277,3	282,8	<p>Мандалговь хүнс ХХК нь тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оныхоос 2 хувиар буюу 5,546 тн-оор нэмэгдүүлж 282,8тн-д хүргэсэн байна.</p>	
16	Хүнсний гол нэрийн төрлийн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, үр дүнг тооцож тайлагнах	хувийн хэвшил- 720,8 сая.төгрөг	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн хувь	39,24	46,1	<p>Орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн- 216.3 тонныг үйлдвэрлэж – 9 хувийг, Сүү, сүүн бүтээгдэхүүн –3,1 мян.л-ийг үйлдвэрлэж -0.09</p>	100

						хувийг, өндөг -77 тонныг үйлдвэрлэж 28 хувийг, мал төхөөрөх цэгт 237.5 тн мах бэлтгэж 14.1 хувийг тус тус хангаж, нийт 51.19 хувийг хангасан байна. Өмнөх оноос 11,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
17	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх (192.2 сая.литр*)	Хувийн хэвшил - 10,0	Боловсруулсан сүүний хэмжээ мян.л	3,3	4,0	Аймгийн хэмжээнд 3,6 мян.литр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж 0,4 тн сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж хүн амын хэрэгцээнд стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтойгоор нийлүүлж байна.	100
18	Хүнсний үйлдвэр, цех, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний байгууллага, хүний нөөцийн судалгааг салбар тус бүрээр шинэчлэн гаргах	-	Судалгаатай болсон салбарын тоо	3	3	Хүнсний 4 чиглэлээр 23 үйлдвэр цех үйл ажиллагаа явуулж /талх нарийн боов, мах, сүү савласан ус/ үйлдвэрлэлийн хүчин чадлыг 100 хувь ашиглаж байна. Эдгээр үйлдвэр, цехүүдэд нийт 85 хүн ажиллаж байна.  Хоол үйлдвэрлэлийн салбарт төрийн байгууллагын /ЕБС.СӨБ/ болон иргэн, хувийн хэвшлийн /Зоогийн газар,	100



						<p>караоке, баар цайны газар/ нийт 145 байгууллага үйл ажиллагаа явуулж 436 хүнийг ажлын байраар хангаж ажиллаж байна.</p> <p>Худалдааны салбарт хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг 148 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 402 хүнийг ажлын байраар хангаж байна.</p> <p>Хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, худалдаа гэсэн 3 салбарын хүрээнд хүний нөөц, үйлдвэрийн хүчин чадал, үйл ажиллагааны чиглэлийн талаарх судалгааг шинэчлэн гаргасан.</p>	
19	Согтууруулах ундаа үйлдвэрлэх (уламжлалт технологиор), худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн, мэдээллийг ирүүлэх (мэдээллийн санд бүртгэх)	-	Уламжлалт технологийн үйлдвэрлэлийн мэдээлэл хүргүүлсэн эсэх	0	1	Тус аймагт уламжлалт технологиор согтууруулах ундааны үйлдвэрлэгч байхгүй тухай мэдээллийг газрын даргын 2024 оны 06 сарын 17 өдрийн 01/130 албан бичгээр ХХААХҮЯамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн.	100

			Үйлчилгээ эрхэлж байгаа тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн судалгааг хүргүүлсэн эсэх	1	1	Сумдаас согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхлэгч тусгай зөвшөөрөлтэй 106 ААНэгжүүдийн судалгааг авч нэгтгэн ХХААХҮЯамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн.	
20	Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх	ОНТ-	Нийлүүлсэн бүтээгдэхүүний нэр төрлийн тоо	8	10	Жайка Олон улсын байгууллагаас хэрэгжиж байгаа Үдийн хоолны загвар төсөлд сонгогдсон 2 сургуулийн хоол, хүнсний хангамжид орон нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч Сайнцагаан сумын “Цэвэр шимт ургац” хоршоо нь амтат чинжүү, өргөст хэмх, брокколи, шар, ногоон хулуу, тарвас зэрэг 6 нэр төрлийн хүнсний ногоог, Мөн Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны хангамжид Мандалговь хүнс, Говийн Гэгээ ХХК-иуд нь 2 нэр төрлийн талх, 4 нэр төрлийн нарийн боов, Номгон рашаан, Их хайрхан мандал, Өнгүүр хадаа ХХК-иуд мах, сүү, сүүн зэрэг нийт 14 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж байна.	50

			Нийлүүлсэн бүтээгдэхүүний хэмжээ /тн/	Мах-24тн Сүү-2,9 Гурилан Бүтээгдэх үүн-8,4тн Хүнсний Ногоо- 0,7тн	Мах- 25тн Сүү-3,2 Гурилан Бүтээгд эхүүн- 9,0тн Хүнсний Ногоо- 1,0тн	2024-2025 оны хичээлийн жилд Дээрх иргэн ААнэгжүүд нь Мах 24 тн, Сүү-2,9, Гурилан бүтээгдэхүүн 8,4 хүнсний ногоо 0,7тн-ыг тус тус нийлүүлсэн байна.	
21	Аймгийн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах	УТ-13,6	Сорилтын лабораторид шинжлэгдсэн шаардлага хангаагүй сорьцын тоог бууруулах /хувь/	3,97	3,67	Итгэмжлэгдсэн Сорилтын лабораторид 2024 онд 1534 сорьцод 5392 үзүүлэлтээр шинжилгээ хийгдсэнээс 86 сорьц стандартын шаардлага хангахгүй эерэг гарсан нь нийт сорьцын 5,6%-ийг эзэлж байна. Стандартын шаардлага хангаагүй сорьцын эзлэх хувь өмнөх оноос өссөн нь 2 удаагийн хоолны хордлогын хүнс, ус, эрүүл зүйн шинжилгээний сорьц шинжлэгдсэнтэй холбоотой байна.	0

22	Орон нутгийн онцлог бүхий уламжлалт брэнд хоол, идээ ундааг шинээр бий болгох, хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	Хувийн хэвшил- 3,5 сая	Судалгаа хийсэн эсэх /Тийм-1, үгүй-0/	0	1	Орон нутгийн онцлог бүхий уламжлалт хоол, идээ ундааны талаарх судалгааг “Хоол үйлдвэрлэлийн салбар”ын ахмад тогооч нараас тодруулга авч ярилцлага зохион байгуулсан. <b>Уламжлалт хоолны төрөл нь:</b> Хүндэтгэлийн зоог буюу Чанаж боловсруулсан бүхэл мах /дал 4 өндөр, хонготой шаант/ Хярамцагтай шөл /5 цулын шөл/ <b>Идээ ундааны зүйл нь:</b> бог малын сүү цагаан идээ буюу ааруул, гүзээлсэн цагаан тос, мөн гүүний айраг, ингэний ааруул, хоормог, хоолны амтлагч даршилсан хөмүүл гэх мэт хүнсийг одоог хүртэл үе уламжлан хоол хүнсэндээ хэрэглэсээр байна. -Орчин үед “Гүзээний хорхог” /бог малын гүзээ 5 цул, толгой шийр/ гэх шинэ нэр төрлийн хоол гарч иргэдийн идэх дуртай хоолны нэг болжээ.	100
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	“Говийн өнгө-2024” арга хэмжээний хүрээнд орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг сурталчлах зорилгоор цагаан идээний	

					<p>болон хоолны үзэсгэлэнг зохион байгуулсан. Үзэсгэлэнд хоол, үйлдвэрлэлийн салбарын 23 иргэн, ААНэгж, цагаан, идээгээр 104 малчин оролцож уламжлалт идээ ундаагаа сурталчилсан.</p> <p>Хүнс, хөнгөн үйлдвэрийн яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд Сайнцагаан сумын өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн Цэцэгмаа, Дэлгэрцогт сумын иргэн С.Цэцэгмаа, Д.Буян-Орших, Д.Мөнхжаргал даршилсан хөмүүл, цагаан идээгээр оролцож хүн амын хэрэгцээнд худалдан борлуулсан.</p> <p>Арга хэмжээний үеэр Говийн бүсийн өдөрлөгөөр уламжлалт ундаа болох “Айраг”ийг олон түмэнд сурталчлан түгээх зорилгоор “Дэмбээ”-ний тэмцээн зохион байгуулсан. “Нүүдэлчин фестиваль”-д Сайнцагаан сумын иргэн Д.Мөнхжаргал,Сарнай нар сүү цагаан идээгээр оролцож орон нутгийн онцлог бүтээгдэхүүн болох</p>	
--	--	--	--	--	---	--

						хөмүүл, ааруулаа сурталчлан худалдан борлуулж олны хүртээл болгосон байна.	
23	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг нэмэгдүүлсэн байх	ОНТ-500,0 сая	Махны үйлдвэр байгуулах төсвийг орон нутгийн төсөвт тусгах	0	1	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны ОНХСангийн хөрөнгөд 0,5 тэрбум төгрөгийг төсөвлөсөн боловч, махны үйлдвэр байгуулах шаардлага хангах ААНэгжийн санал ирээгүй. Орон нутгийн үйлдвэрлэлээр 16 тн бууз, баншийг үйлдвэрлэж эрүүл аюулгүй, стандартын шаардлагад нийцсэн сав баглаа боодолтойгоор хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн байна. Сайнцагаан, Говь-Угтаал суманд үйл ажиллагаа явуулдаг мал төхөөрөх 5 цэгт 237.5 тн махыг бэлтгэн Улаанбаатарын зах зээлд борлуулсан байна. ЖДҮХСангаас мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	50

						чиглэлээр Говь наран ХХК-180 сая.төг, Хулд мандал ХХК-70,0 сая. төг, эрчимжсэн мах, сүүний аж ахуйн эрхлэх чиглэлээр Эргэх говь ХХК-90,0 сая. төг, Адаацаг хонгор хайрхан-90,0 сая.төгрөг нийт 430,0 сая. төгрөгийн санхүүжилтэд хамрагдсан.	
<b>Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр</b>							
24	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад батлагдсан Засгийн газрын “Жагсаалт батлах тухай” 2023 оны 409 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/4514 тоот бичигт дурдсан зөвлөмжийг хангаж ажиллах	УТөсөв-	Зөвлөмжийг ханган ажилласан эсэх (Тийм-1), (Үгүй-0)	1	1	“Шинэ хөдөө” төслийн хүрээнд 2023 онд Сайнцагаан суманд-4, Луус суманд-1, Хулд суманд-1, Эрдэнэдалай суманд-1, Говь-Угтаал суманд-1, Дэлгэрхангай суманд-1 Дэлгэрцогт суманд-1 нийт 10 суманд дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны хүлэмж - 10ш , Хүнсний ногооны гар үрлэгч - 2 ш нийт 2 төрлийн тоног төхөөрөмж 72 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 2.Эрдэнэдалай суманд Арьс шир боловсруулах тоног, төхөөрөмжийг олгож, төхөөрөмжийг суурилуулах арьс, шир, ноос боловсруулах зориулалт бүхий 32*6 харьцаатай 4 өрөө ажлын байрыг	100

						ОНТөсөвт санхүүжилтийг суулган барьж байна. Барилгын явц 40 хувьтай явагдаж байна Тус төхөөрөмжийг ашиглах гэрээг иргэн У.Энхбаяртай байгуулан ажиллаж байна. Төсөлд хамрагдаж хөрөнгө оруулалт авсан сумд хөрөнгүүдийг ЗДТГын үндсэн хөрөнгөд бүртгэж, иргэдэд гэрээгээр ашиглуулж байна. Зөвлөмжид тусгагдсан зөрчил тус аймагт байхгүй болно.	
<b>Салбарын хяналтын чиглэлээр</b>							
25	Мал үржлийн чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхэд дэмжлэг үзүүлэх. (хавсралт хүснэгт)	-	Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо	15	10	Төлөвлөгөөт хяналт шалгалтад 10 объектыг хамруулж 91 зөрчил дутагдлыг илрүүлж улсын байцаагчийн 38 заалт бүхий 6 зөвлөмж, 29 заалт бүхий 3 албан шаардлагаар үүрэг, зөвлөгөө өгч 73,6%-ийг нь арилгуулан ажилласан.	100
26	ЗГ-ын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан“Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ын хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн хэмжээнд үйлдвэрийн аргаар мал төхөөрөх асуудлыг шийдвэрлэх, суурьшлын бүс,	Хувийн хэвшил-	Их эрсдэлтэй үнэлэгдсэн мал төхөөрөх 2 объектын эрсдэлийн бууралтын хувь	81,7%	61,7%	Тус аймагт үйл ажиллагаа явуулж байсан мал төхөөрөх 2 объектод 2023 оны 12 сард хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар өгсөн улсын байцаагчийн хамтарсан албан шаардлагын	100



	нийтийн орон сууц, сургуулийн ойролцоо байрласан мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд дэд бүтэц инженерийн шугам сүлжээнд холбогдсон бохирдуулагч эх үүсвэрээс 500м зайтай үйлдвэрийн бүсэд газар олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулах, хөрөнгө оруулахад шийдвэртэй арга хэмжээ авч ажиллах /Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Дундговь, Дорноговь гм/					хэрэгжилтийг шалгаж хэрэгжүүлэн ажиллаа. Хяналт шалгалтаар эрсдэл үүсэх магадлал 21 хувиар буурч 60 хувь болсон.	
<b>Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр</b>							
27	Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжид бодлогоор дэмжлэг үзүүлэх, иргэнийг ажлын байртай болгох, жижиг, дунд үйлдвэрт нь хөнгөлөлттэй зээл олгох	ЖДҮХСан-300,0 сая.төгрөг	Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	0	1	Улаанбаатар хотоос Дэлгэрэх плас инженеринг ХХК нь шилжин ирж ЖДҮХСангаас Ахуй үйлчилгээний чиглэлээр 300,0 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Тус зээлийн дэмжлэгтэйгээр 990м2 үйлчилгээний төвийг барьж ашиглалтад оруулаад байна. Шинээр 10 иргэнийг ажлын байраар хангасан. Хулд мандал ХХК нь Улаанбаатар хотоос шилжин ирсэн 2 иргэн, Тэгш наран би ХХК нь Хэнтий аймгаас шилжин ирсэн 2 иргэн, Мянгат алтан судар хоршоо Улаанбаатар хотоос	100

						ирсэн 2 иргэн, Сэлэнгэ аймгаас шилжин ирсэн 2 иргэн нийт 8 иргэнийг тогтмол ажлын байраар хангасан байна.	
			Ажлын байрны тоо (Орон нутагт шилжин ирсэн иргэнийг ажлын байраар хангасан)	1	2	Хадгалагдсан ажлын байр 4. Шинэ ажлын байрны тоо 18.	
28	Үндэсний үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж, Орон нутагт бүтээн байгуулалт хийж байгаа төсөл хөтөлбөр, уул уурхай, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж, борлуулалтыг дэмжих, гадаад, дотоодын зах зээлийг өргөтгөх	Хувийн хэвшил-84,0 сая.төг	Нийлүүлсэн бүтээгдэхүүний нэр, төрөл (тоо)	3	4	Орон нутгийн иргэн, ААНэгжээс уул, уурхайн компаниудад 4 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж байна. Үүнд: Ажлын өвөл, зуны хувцас, ажлын бээлий, мах, сүү	100
			Нийлүүлсэн бүтээгдэхүүний хэмжээ (сая.төг)	70	80	Орон нутгийн оёдлын үйлдвэр нь уул, уурхайн компаниудад өвлийн ажлын хувцас-50 ш, зуны ажлын хувцас-100 ш нийлүүлж нийт 31,5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.  Баянжаргалан сумын 4, Гурвансайхан сумын 2, Говь-Угтаал сумын 1, Өлзийт сумын 1 нь орон нутгийн малчдаас уул, уурхайн компаниудад нийт 3,5 тн мах, 200 литр сүү нийлүүлж 52,5 сая.төгрөгийн борлуулалтын орлого олсон байна. Орон нутгаас нийт	

						84,0 сая.төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	
29	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх	ОНТ-	Эх үүсвэрийг нэмэгдүүлсэн хэмжээ (сая.төг)	-	-	Аймгийн ИТХ-ын ээлжит гуравдугаар хуралдаан 2024 оны 12 сарын 20 өдөр хуралдаж, Орон нутгийн төсөвт Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зориулалтаар 400.0 сая төгрөгийг баталж хэрэгжүүлэхээр болсон. 2024 онд ЖДҮХСангаас 12 ААНэгжид 1,570,000,000 төгрөг олгож, шинээр 44 ажлын байр бий болж, 30 ажлын байр хадгалагдсан байна.	80
30	“Хоршоог хөгжүүлэх сан”-ийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хоршоог хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээллийг сар бүр шинэчилж олон нийт дүгнэлт хийх боломжтойгоор цахим хуудастаа нээлттэй ил, тодоор байршуулах	-	Чанаргүй зээлийн хэмжээг бууруулах	24,23	14,23	2011-2023 онд ХХСангаас нийт 699 иргэн, ААНэгжид зээл олгосон. Одоогийн байдлаар 225 зээлийн үлдэгдэлтэй иргэн байгаагаас 32 иргэн муу зээлийн түүхтэй байна. Энэ нь өнгөрсөн онд 24,23 хувь байсныг 14,22 хувь болгон бууруулан ажилласан байна.	100

		-	Цахим хуудас, мэдээллийн салбарт байршуулсан мэдээллийн тоо	3	4	Хүнс, хөдөө аж ахуйн газрын <a href="https://du.hhaag.gov.mn">https://du.hhaag.gov.mn</a> сайтад ЖДҮ, Хоршоотой холбоотой 6 удаагийн мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэсэн. Уг мэдээллүүд Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар гэсэн facebook хуудсаар давхар тавигдан олон нийтэд хүрч байна.	100
31	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн чанаргүй муу зээлийн хэмжээг бууруулахад онцгой анхаарч, зээл төлүүлэх асуудлаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах	-	Авлагын хэмжээг 30 хувиар бууруулах	88.6 сая.төг	62.0 сая.төг	ЖДҮГазрын даргын 2024 оны 4 сарын 3-ны өдрийн А/77 тоот тушаалаар ЖДҮХСангаас зээл авсан зээлдэгч нарт мониторинг хийх удирдамжийн дагуу 2024.10.18-2024.11.15 өдрүүдэд хяналтыг зохион байгуулсан. Хяналт хийгдсэнээр 72.6 сая.төгрөгийн авлагыг төлүүлсэн. Ингэснээр авлагыг 81.9 хувиар бууруулсан байна.	100
			<b>Салбарын судалгаа хөгжлийн чиглэлээр</b>				
32	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах	Улсын төсөв-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	1	Судалгаа хөгжлийн төв, аймгийн ХХААГ-тай хамтран 2024 оны 11 сарын 08 өдөр "Үр ашигтай мал аж ахуйг эрхлэх-Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой	

						<p>дадал” сэдвээр тусгай хөтөлбөрт тусгагдсан 12 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Тус сургалтад ХХААГ-аас 8 албан хаагч, 15 сумын хөдөө аж ахуйн тасгаас 16 мэргэжилтэн, ногоочин-4, түүхий эд бэлтгэлийн ченж-8 нийт 36 хүн хамрагдсан.</p> <p>2.Өлзийт, Дэрэн, Хулд, Дэлгэрхангай сумдын малчдын зөвлөгөөнд ХХААГ-ын мэргэжилтнүүд оролцож цахилгаан хайчаар хонь хяргах технологи, ямаа самнах үеийн тавлаг байдал, технологи зааварчилгаа, ноос ноолуур бэлтгэх арга зүй, малын тэжээлийн ургамал тариалах технологи зэрэг мал аж ахуйн салбарын сургалтыг 5 удаа 454 малчид, иргэдийг хамруулан зохион байгуулсан байна.</p>	100
			Хамрагдсан иргэдийн тоо	-	1	Нийт 454 малчид, иргэд хамрагдсан	
33	Хүлэмжийн аж ахуйн технологийн сургалтыг хамтран зохион байгуулах	Төсөл хөтөлбөр-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	1	1.“Дундговвио ногооруульа” дэд хөтөлбөрийн хүрээнд хүлэмж, жимс, жимсгэний мод тарьж ургуулах, газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдэд агротехнологийн сургалтыг	

					<p>04 сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулж, 15 сумын 71 тариаланч, төрийн байгууллагын ногоо тарих сонирхолтой 54 албан хаагч нийт 125 иргэнийг хамруулсан. Тариаланчдад хүлэмжийн талбайд үзүүлэх сургалтыг зохион байгуулж, туршлага судлуулсан.</p> <p>2.ХХААГ-ын агрономич нь албан байгууллагуудын ирүүлсэн хүсэлт, ажлын чиг үүргийн дагуу 5 төсвийн байгууллагын 25 албан хаагчид хүлэмжийн тариалалт болон төмс, хүнсний ногооны тариалалтын технологиор заавар, зөвлөгөөг талбайд өгч хамтран ажилласан.</p> <p>3.ЕБС-ийн “Үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих” төсөл Япон улсын Жайка олон улсын байгууллагатай хамтран 2024 оны 01 сарын 19 өдөр нийт 28 ногоочинд хүлэмжийн аж ахуйн технологи болон төмс хүнсний ногоо тариалах чиглэлээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтыг ХХААХҮ-ийн судалгаа хөгжлийн төвийн ахлах мэргэжилтэн</p>	100
--	--	--	--	--	--	-----

						<p>С.Нандинцэцэг, Япон улсын Жайка олон улсын байгууллагын хүнсний хангамжийн тогтолцоог хариуцсан зөвлөх РИЭРА АСАКО болон ХХААГ хамтран зохион байгуулсан. Төсөлд хамрагдсан 10 ногоочинд хүнсний ногооны 15 нэр төрлийн 1,4 кг, буюу 11,0 сая төгрөгийн үрийг хуваарилан олгож тариалалтыг дэмжиж ажилласан.</p> <p>3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын хамтран Дорнод аймагт зохион зохион байгуулагдсан газар, тариалангийн технологийн сургалтад Экстейшин хариуцсан мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>Нийт 4 удаагийн сургалтаар 179 иргэд, ногоочид хамруулсан.</p>	
			Хамрагдсан иргэдийн тоо	-	1	Нийт 179 иргэд, ногоочид хамрагдсан.	
34	Арьс ширний чанарын тогтолцоог нэвтрүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах	Төсөл хөтөлбөр-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	1	Судалгаа хөгжлийн төв, аймгийн ХХААГ-тай хамтран, 2024 оны 11 сарын 08 өдөр “Үр ашигтай мал аж ахуйг эрхлэх-Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой	100

					<p>дадал” сэдвээр тусгай хөтөлбөрт тусгагдсан 12 сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад ХХААГ-аас 8 албан хаагч, 15 сумын хөдөө аж ахуйн тасгаас 16 мэргэжилтэн, ногоочин-4, арьс, шир түүхий эд бэлтгэлийн ченж-8 нийт 36 хүн хамруулж чадавхжуулсан. Сургалтын хөтөлбөрт тусгагдсаны дагуу “Арьс, ширэн түүхий эдийн бэлтгэл, стандарт, чанар” сэдвээр Хөнгөн үйлдвэрлэлийн инновац, нэвтрүүлэлт хариуцсан мэргэжилтэн Б.Отгонбулаг, ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мөшгих тогтолцоо сэдвээр Инкубатор хариуцсан мэргэжилтэн Б.Урангоо нар сургалт, мэдээлэл өгсөн. 2024 оны 11 сарын 25 өдөр Өлзийт суманд зохион байгуулагдсан Малчдын зөвлөгөөнд оролцсон 215 малчинд МҮАлбаны мэргэжилтэн Э.Уугандорж дээрх сэдвээр сургалт, мэдээлэл хийсэн. Нийт 2 удаагийн сургалтаар 215 малчид, иргэд хамрагдсан</p>	
--	--	--	--	--	--	--



			Хамрагдсан иргэдийн тоо	-	1	Нийт 215 малчид, иргэд хамрагдсан	
<b>Малын удмын сангийн чиглэлээр</b>							
35	“Сайнцагаан” омгийн хонины хуцнаас үр авч Монгол улсын малын үндэсний генийн санд хадгалах ажлыг орон нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж хэрэгжүүлэх	ОН-500,0	Авсан үрийн хэмжээ /тун/	0	500	Малын удмын сангийн үндэсний төвд Сайнцагаан омгийн 2 хуцанаас 300 тун, Өндөршил омгийн 2 азарганаас 200 тун үрийг тус тус туршилтаар аваад байна.	100
<b>Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын чиглэлээр</b>							
36	Аймаг дундын отрын бүс нутагт өвөлжүүлэх малыг мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамруулан, баталгаажуулж оруулах ажлыг зохион байгуулах	ОН-	Отроор өвөлжиж хаваржуулсан малын тоо	0	10000	2024-2025 оны өвөл, хавар аймгийн хэмжээнд 2024-2025 онд 7347 малчин өрх, 1474 мал бүхий өрхийн 3,4 сая толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 4,7 сая толгой мал өвөлжиж, хаваржихаар бэлтгэл хангагдсан. Үүнээс гаднын аймаг, сумдад 53 өрхийн 33850 толгой мал, өөрийн аймгийн өөр сумдад 23 өрхийн 18551 толгой мал тус тус отор нүүдлээр өвөлжиж байна.	100
<b>Мал эмнэлгийн чиглэлээр</b>							
37	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд нь зохион байгуулах	305 сая	Дархлаажуулалтад хамрагдсан малын тоо	362,000	262,000	Дотрын халдварт хордлого, энтеробактериоз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 15 сумын малчин 668 өрхийн 261,511 толгой бог малыг давтан тунгаар 2 удаа	100

						хамруулсан. Дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 3 сумын малчин 82 өрхийн 403 толгой тугал, бяруу, 1557 толгой үхэр нийт 1960 үхэр хамруулсан. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 263471 толгой мал хамруулсан.	
38	Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж, устгах, гоц халдварт, халдварт өвчний голомтын, сэжигтэй бүсийн бэлчээр, ус эх булаг, малын өвөлжөө, хаваржаа хэвтэр бууц хашаа хороог цэвэрлэх халдваргүйтгэх арга хэмжээг зохион байгуулах	5 сая	Устгасан сэг зэмийн тоо	25288	250 000	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/115 дугаар захирамжаар зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах ажлын хэсгийг 5 байгууллага, 15 сумын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Малын сэг зэмийг цуглуулж, булшилж устгах ажлыг зохион байгуулж тэмээ 341, адуу 33404, үхэр 8743, хонь 126313, ямаа 112318 нийт 281119 сэг зэмийг устгасан.	100
			Ариутгал халдваргүйтгэл хийсэн талбайн хэмжээ	1368260 мкв	1500.00 Омкв	Устгалын цэгийн 95362 талбай /м2/, Голомтын 28 цэгийн 5660м2, Нийтийн эзэмшлийн талбай 101665 м2, 4801 хашаа, хорооны 2231830 м2, 71 өтөг бууц	

						4516м2, 3720 худаг, уст цэгийн 230615 м2, Бэлчээрийн талбай 700500 /м2/, 9 агуулах, зоорь, түүхий эд агуулах цэг 4100м2, Түүхий эд агуулах 2 цэг 2420 /м2/, Тэжээлийн агуулах 4 цэгийн 1520/м2/, 289 тээврийн хэрэгсэл 3900 м2, Нийт 3.382.088 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн.	
39	Сумын мал эмнэлгийн тасгийг холбогдох хуулийн дагуу мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, бүтэц орон тоогоор нь ажиллуулах, орон нутгаас малын эмчийг ХААИС-н МЭС-тай гэрээ байгуулан захиалгаар сургах ажлыг зохион байгуулах	7 сая	Шинээр малын эмчтэй болсон мал эмнэлгийн тасгийн тоо	12	15	Аймгийн Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2024 онд ХААИС-н МЭС-тай гэрээ байгуулан 5 дугаар курсийн 1 оюутны жилийн төлбөрийг төлж төгссөн. Тус оюутан гэрээний дагуу Адаацаг сумын Мал эмнэлгийн тасагт мэргэжилтнээр ажиллаж байна. 12 сумын Мал эмнэлгийн тасгийн тасагт 28 мэргэжилтэн ажиллаж байна.	100
							91.5

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С. МӨНХЧУЛУУН

ХЯНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.УЯНГА

ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЭТИЙН ЗОРИЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.СОЛОНГО

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  С.МӨНХЧУЛУУН

ХЯНАСАН:


ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.УЯНГА

ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.СОЛОНГО

